

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хувь хүний орлогын албан татварын
тухай хуульд нэмэлт оруулах тухай
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасан байдаг. Энэ нь иргэн бүр хөдөлмөр эрхлэхдээ эрх чөлөөтэй байх, шударгаар үнэлүүлж, зохих урамшуулал, бодит орлогоо хүртэх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах үндсэн эрхтэйг баталгаажуулдаг.

Монгол Улсад хөдөлмөрийн хуулийн хүрээнд илүү цагаар ажилласны цалин хөлсийг зохих журмын дагуу ажил олгогчоос олгохоор заасан ч, тухайн орлогод хувь хүний орлогын албан татвар ногдуулж байгаа нь ажилтны бодит орлогыг бууруулж, хөдөлмөрийн үнэлэмжийг багасгах, цаашлаад хөдөлмөр эрхлэлтийн идэвхийг сааруулах сөрөг үр дагавартай байна. Ялангуяа төрийн үйлчилгээний (боловсрол, эрүүл мэнд зэрэг) салбарт илүү цагаар ажиллах явдал түгээмэл бөгөөд энэ нь ажилтан, байгууллагын ачааллыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлдөг.

Энэ хуулийн өөрчлөлт хийгдснээр хөдөлмөрийн үнэлэмжийг бодитоор тогтоох, урамшууллын системийг бий болгох, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, нийгмийн шударга байдлыг хангах чиглэлд томоохон алхам болох юм.

Хуулийн төслийн үндсэн зорилго нь ажиллагсдын илүү цагийн цалин, орлогын зарим хэсгийг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх замаар хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, орлогын ялгааг бууруулах, татварын бодлогоор дамжуулан нийгмийн шударга байдлыг дэмжихэд оршино.

Хуулийн үйлчлэл нь хөдөлмөрийн гэрээний дагуу илүү цаг ажилласан, хуулийн дагуу нэмэгдэл хөлсөнд хамаарах илүү цагийн хөлс авах дараах ажилтан, алба хаагчдад хамаарна. Үүнд:

1. Боловсролын салбар /Ерөнхий болон мэргэжлийн боловсролын байгууллагын багш, сургалтын туслах зэрэг ажилтнууд нь хичээлийн бус цагаар сургалт зохион байгуулах, даалгавар шалгах, тайлан гаргах зэрэг нэмэлт ажлыг тогтмол гүйцэтгэдэг. Илүү цагийн ажлыг үнэлэн татвар, шимтгэлээс чөлөөлснөөр багшийн ачааллыг бууруулах, урамшууллыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болно./
2. Эрүүл мэндийн салбар /Эмч, сувлагч, яаралтай тусламжийн болон эрчимт эмчилгээний ажилтнууд шөнийн ээлж, амралт, баярын өдрүүдээр илүү цагийн ажлыг тогтмол гүйцэтгэдэг. Илүү цагийн орлогыг татвараас чөлөөлөх нь салбарын нөхцөл, ачааллыг бодитоор үнэлсэн дэмжлэг болно./
3. Хууль сахиулах, тусгай үүргийн байгууллагууд /Цагдаа, онцгой байдал, зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагын алба хаагчид онцгой нөхцөлд, тасралтгүй ажиллагааны горимоор ажилладаг тул илүү цагийн хөдөлмөрийг зөв үнэлэх нь нийгмийн баталгаанд чухал ач холбогдолтой./

4. Тээвэр, логистикийн салбар /Жолооч, ачигч, агуулахын ажилтнууд уртасгасан цагаар ажиллах шаардлагатай байдаг. Илүү цагийн орлогыг татвараас чөлөөлөх нь хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж, ажиллах хүчний тогтвортой байдлыг хангана./
5. Барилга, уул уурхайн салбар /Богино хугацаанд их хэмжээний ажлыг улирлын онцлогт тулгуурлан гүйцэтгэх шаардлагатай байдаг тул илүү цагийн хөдөлмөр нийтлэг үзэгдэл. Цалин, орлогыг татвар, шимтгэлээс чөлөөлөх нь ажилчдын бодит орлогыг нэмэгдүүлнэ./
6. Хөдөө аж ахуйн салбар. /Тариалалт, ургац хураалт зэрэг богино хугацаанд тасралтгүй хөдөлмөр шаарддаг ажлуудад оролцож буй ажиллагсад илүү цагийн нэмэлт орлогоосоо татвар төлөхгүй байх нөхцөл бүрдсэнээр улирлын чанартай хөдөлмөрийн урамшуулал нэмэгдэнэ./

Энэхүү хууль нь төрийн, хувийн хэвшлийн ажилтанд ижил тэгш хамаарах бөгөөд илүү цагийн хөдөлмөр нь хууль, журмын дагуу баталгаажсан байх шаардлагатай.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зохицуулалтыг нэмж тусгав. Үүнд: Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11-т “...долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдэл хөлс болон хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтоон олгож байгаа тэдгээртэй адилтгах бусад нэмэгдэл хөлсийг” буюу нэмэгдэл хөлсний зарим хэсгийг хэмээн нэмж албан татвараас чөлөөлөх орлогод хамааруулж тусгав.

Нэмэгдэл хөлсний зарим хэсгийг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт орсноор ажилтан, алба хаагчдын бодит орлого нэмэгдэх, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, орчныг сайжруулах, нийгмийн тодорхой бүлгийн амьжиргаанд эерэг нөлөө үзүүлэх бодит үр нөлөө гарна.

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажиллаж буй иргэдийн хувьд илүү цагаар ажилласны төлбөрөөс татвар суутгахгүй байх нь тэдний бодит орлогыг нэмэгдүүлж, өрхийн санхүүгийн боломжийг сайжруулна. Энэ нь эрүүл мэнд, боловсрол, онцгой байдал, цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын ажилтнууд зэрэг төрийн үйлчилгээний онцгой ачаалалтай салбаруудад илүү цагийн хөдөлмөрийн урамшууллыг бодитой болгох, тэгш шударга нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Энэхүү зохицуулалт нь иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүний нөөцийн удирдлагыг уян хатан болгох эерэг нөлөөтэй. Илүү цагийн хөдөлмөрийн үнэлэмж бодитой болсон нөхцөлд ажилтан тухайн ажлыг үр бүтээлтэй, хариуцлагатай гүйцэтгэх хандлага нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг өсөх боломж бүрдэнэ.

Орлогын албан татварын бодлогод шударга, уян хатан зохицуулалт бий болж, бага, тогтмол орлоготой иргэдийн татварын ачаалал буурна. Энэ нь нийгмийн дундаж

давхаргын төлөөллийг дэмжих, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах чиглэлд хувь нэмэр оруулна.

Энэ хууль нь салбарын онцлогт нийцсэн татварын дэмжлэгийн бодлогын шинэ жишиг тогтоох ач холбогдолтой. Ялангуяа өндөр ачаалал бүхий нөхцөлд ажилладаг боловсон хүчнийг тогтоон барих, ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн хүний нөөцийг тогтвортой байлгах, нийгмийн үйлчилгээний салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд шууд болон шууд бусаар эерэг нөлөө үзүүлнэ.

Иймд энэхүү хуулийн хэрэгжилт нь ажил олгогч, ажил эрхлэгч талуудын эрх ашигт нийцсэн, нийгэм, эдийн засгийн хувьд оновчтой шийдэл болохоос гадна татварын бодлогыг илүү шударга, тэгш хүртээмжтэй болгох алхам болно.

Бусад хууль тогтоомжид нийцэх байдалын хувьд Хүн амын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шударгаар олсон орлогоо захиран зарцуулах, хөдөлмөрлөх, хөдөлмөрийн шударга үнэлэмжтэй байх үндсэн эрхийг хангах зорилготой бөгөөд Үндсэн хуулийн үзэл баримтлалтай бүрэн нийцэж байна.

Түүнчлэн тус хуулийн төсөл нь Хөдөлмөрийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжид нийцнэ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулж, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр нийгэм хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/192 дугаар хавсралт Дундаж цалин хөлс тодорхойлох журамд журамд заасан нэмэгдэл хөлсний зарим хэсэг буюу "...илүү цагаар, шөнийн цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баярын өдрөөр ажилласны нэмэгдэл хөлс болон хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтоон олгож байгаа тэдгээртэй адилтгах бусад нэмэгдэл хөлс..."-ийг албан татвараас чөлөөлөх орлогод хамруулах зохицуулалтыг тусгана. Энэ нь татвар ногдуулах орлогын хүрээг шинэчлэн тодорхойлох замаар илүү цагийн хөдөлмөрийг зохих ёсоор үнэлэх, ажиллагсдын бодит орлогыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Онцгой байдлын тухай хууль, Боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль зэрэг төрийн үйлчилгээний салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тусгай хуулиудад шаардлагатай тохиолдолд илүү цагийн урамшууллын зарим хэсгийг татвараас чөлөөлөхтэй холбогдуулан холбогдох өөрчлөлт, уялдаа бүхий зохицуулалтыг тусгах шаардлага үүсэж болзошгүй.

---oOo---

